



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/10

Бодь

Залуучуудын салбар зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, нийгмийн олон талт ажилд идэвхтэй оролцуулахад дэмжих, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах сумын залуучуудын салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч Н.Сумъяа - Засаг даргын орлогч

Гишүүд

Б.Алтанхуяг – Залуучуудын холбооны тэргүүлэгч

О.Баасанбат – Нийгмийн даатгалын байцаагч

М.Бямбатогоо – Архив, бичиг хэргийн эрхлэгч

Д.Наранбаатар – Хүйс 2 дугаар багийн Засаг дарга

2.Салбар зөвлөлийг удирдлага арга зүйгээр хангаж, жил бүр хийх ажлын төлөвлөгөөг багийн гишүүдээр хэлэлцүүлэн боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг багийн ахлагч (Н.Сумъяа)- д даалгасугай.

3.Залуучуудын эрх ашгийг хамгаалах, нийгмийн идэвх оролцоог дээшлүүлэхэд анхаарч, иргэний нийгмийн байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллахыг салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулж 2021 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн А/58 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Р.БАТЖАРГАЛ



642101097